



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/92

Хатан суудал

Үндэсний их баяр наадам тэмдэглэн
өнгөрүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.5 дахь заалтууд, 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.4 дахь заалт, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2010 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 271 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хүннү гүрэн байгуулагдсаны 2232 жил, Их Монгол улс байгуулагдсаны 817 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 112 жил, Ардын хувьсгалын 102 жилийн ойн үндэсний их баяр наадмыг 2023 оны 07 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Баяр наадам зохион байгуулах салбар комиссыг хавсралтаар баталсугай.

3. Баяр наадмын бэлтгэл ажлыг өндөр түвшинд хангаж, наадмын хөтөлбөрийг иргэдэд сурталчлан, сайтар зохион байгуулж ажиллахыг Баяр наадам зохион байгуулах салбар комиссын дарга нарт, иргэдийн аюулгүй байдлыг ханган, нийтийн хэв журам сахиулж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч цагдаагийн дэслэгч (Л.Отгонсүрэн)-д тус тус үүрэг болгосугай.

4. Баяр наадмын зардалд Орон нутгийн хөгжлийн сангаас 5,000,000 (Таван сая) төгрөгийг зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Мөнхсүх), Санхүү албаны дарга (Ш.Хоролсүрэн), сан хариуцсан Нягтлан бодогч (С.Бадамсүрэн) нарт зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Мөнхсүх)-д даалгасугай.

ДАРГА  О.МӨНХБАТ



642301155